



35

**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 31

Номгон

**“Хурандаа цогцолбор” байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг сурталчлах, цэрэг-эх оронч үзэл, ёсзүй, ухамсрыг төлөвшүүлэх, монгол цэргээрээ бахархах үзлийг хүүхэд, залуучуудад олгох зорилгоор Мазаалай паркад “Хурандаа цогцолбор” байгуулсугай.

2. Хурандаа цогцолборын зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхийг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ

